

**ХАС ТЭМДЭГ БОЛ АЛТАН ГАДАС ХИЙГЭЭД ДОЛООН ӨВГӨН
ОДДЫН БАЙРШИЛ, ХӨДӨЛГӨӨНД ҮНДЭСЛЭГДСЭН ОГТОРГУЙ
ЕРТӨНЦИЙН БЭЛГЭ ТЭМДЭГ БОЛОХ НЬ**

Ю.Болдбаатар. ШУТИС, ХУС, Түүх-Хүн судлал. bold@must.edu.mn

Өгүүллийн товч утга: Энэ өгүүлэлд хас тэмдгийг алтан гадас болон долоон өвгөн оддын байршил хөдөлгөөнд үндэслэгдсэн огторгуй ертөнцийн загвар бэлгэ тэмдэг хэмээн нотлохыг зорьсоны зэрэгцээ тэдгээр ододтой холбоотой монголчуудын домгийг өрнө, дорнын ард түмнийхтэй харьцуулан шинжилж, эртний нүүдэлчин монголчуудын одот, огторгуй ертөнцийн тухай үзэл сэтгэлгээний өвөрмөц дүр зургийг илрүүлэхийг хичээсэн болно.

Түлхүүр үг: Долоон өвгөн (Ursa Majoris), Алтан мөнгөн шаргын орд (Ursa Minoris), Тэнгэрийн гох (Cepheus), Умард туйл (Arctus), Тэнгэрийн хас, тэнгэр, тэнгэрийн төв, огторгуй, орчлон ертөнц, орчил хөдөлгөөн, цаг хугацаа, орон зай, домог, хас тэмдэг, бэлгэ тэмдэг

Хас тэмдгийн махбодь бол Алтан гадас од төвтэйгээр, түүнийг тойрох долоон өвгөн одны хосгүй гайхамшигтай байрлал, түүний хөдөлгөөний дөрвөн цагийн эргэлтэнд, дөрвөн зүгтэй хэрхэн зохирч байгаад үндэслэгдэж зохиогдсон одтой тэнгэр, орчлонгийн орон зай, цаг хугацааны, өөрөөр хэлбэл зогсолтгүй эргэх, мөнхийн хэмнэлт хөдөлгөөнийг илэрхийлсэн орчлонгийн хүрдэт, ертөнцийн тэгш хэмт бэлгэ тэмдэг мөн. Энэ нь байгалийн хүрээлэл дундах эртний хүмүүсийн од эрхсийн орчил, хөдөлгөөнийг ажигласан ажиглалтаас эх загвараа авсан тэмдэгт ажгуу.

Тайлбар: Хойт туйлаас нэг градусаар зөрж байрлах Алтан гадас нь дэлхийн бөмбөрцгийн умард хагасынхны хувьд энгийн нүдэнд нэгэн цэгт хөдөлгөөнгүй оршиж харагддагаас хойд зүгийг заагч од болдог. Энэхүү одыг олох хамгийн дөт арга бол Долоон өвгөн одны Тэнгэрийн хас одыг үзүүрийн Тэнгэрийн оргилго одтой шулуун шугамаар холбон, уг хоёр одны хоорондын зайг тав дахин цааш уртасган татвал шугам Алтан гадас одонд хүрдэг. Тэгвэл энэ хоёр од нь Алтан гадас одыг заагч болно. Тэнгэрийн хас од нь Долоон өвгөн оддын цувааг гол өнцгөөр нугалагч /чухам энэ одыг Тэнгэрийн хас хэмээн нэрлэж байгаа нь санамсаргүй хэрэг биш юм/ хийгээд түүнээс төгсгөлийн Жиргэлэх гэрэл од хүртэлх Тэнгэрийн шил, Тэнгэрийн эрх, Тэнгэрийн бэрээ, Нэхэх арга оддыг шугамаар холбож үзвэл шулуун шугам биш ч гэлээ дээрх Тэнгэрийн хасыг Алтан гадастай холбосон шугамтай харьцуулж ажиглахад шөнийн тэнгэрт тэгш өнцөгт үүсгэж харагддаг ба Долоон өвгөн од нь тэнгэрийн бусад оддын адил Алтан гадас одыг

хоногт нэг удаа тойрдог. Тэгвэл Алтан гадас, Тэнгэрийн хас, Жиргэлэх гэрэл гэсэн 3 цэг бүхүй тэгш өнцөг нь 6 цаг тутамд 90° -аар нар зөв эргэх хийгээд үүнийг хоногийн 24 цагт 4×6 буюу $90^\circ \times 4 = 360^\circ$ болж нэг бүтэн эргэлт үүснэ. Эдгээр 6 цаг тутам дахь 4 байрлалыг нэгэн хавтгайд Алтан гадас од төвтэйгээр буулгаж үзвэл (зураг 1) бидний тайлбарлаж буй хосгүй гайхамшигт хас тэмдэг тод илэрч харагдана. Хоногийн нийт хугацааны 6 цаг тутам дахь 4-н байрлалыг авч үзэхэд ийнхүү ажиглагдах бол жилийн 4 улирал дахь ерөнхий байрлалыг, жишээлэхэд 1, 4, 7, 10 саруудын тодорхой өдөр, цагуудад шөнийн тэнгэр дэх байрлалыг тэмдэглэж авбал басхүү орон зайн тэгш хэмт хас тэмдэг тод харагдана. Энэ нь бүхэлдээ Алтан гадас төвтэй тэнгэрийн мандал дахь орон зайн координатын системийг, тэнгэрийн од эрхсийн хөдөлгөөний хэмнэл давтамжийг, цаг, улирлаар ажиглан мэдэж болох бололцоог олгож байна. Ер нь Долоон өвгөн од, Алтан, мөнгөн шаргуудын (Алтан гадас нь энэ ордны α од) ордны одод нь бүгдээр умард туйлын 30° -ийн дотор багтдаг учир жилийн дөрвөн улирлын аль ч үед шөнийн тэнгэрт үзэгддэг. Тиймдээ ч хас тэмдэг мөнхөд оршихуйн утга бэлгэдлийг илэрхийлэгч ажгуу. Иймээс эдгээр оддын байрлал, эргэх хөдөлгөөний хосгүй шинжийг ажиглах боломж нь дэлхийн бөмбөрцгийн умард хагасынханд тохиодог хийгээд эл тэмдэгт бүхүй соёлын дурсгалууд энэ л хагасаас олддогийн дийлэнх дорнынхонд түүний дотор монгол оронд байдаг. Тэдгээрийг судалсан манай судлаачдын олонх уг тэмдгийн бэлгэдлийн утгыг орон зай, цаг хугацаа, орчлон ертөнцийн орчил хөдөлгөөний бэлгэдэл хэмээн тайлбарладаг. Мөн зарим судлаачдын судалгаанд уг тэмдэгийг задлан шинжилж тайлбарлахдаа хэт хальж туйлширсан байдал ажиглагдаж байна. Гэвч эдгээр судалгааны дотор уг тэмдэгт чухам юунаас анх сэдэгдэн сэтгэгдэж зохиогдсон тухайд тодорхой баримт, нотолгоо хомс ажээ.

Долоон өвгөн одны домог, шүтлэгийн учир холбогдол

Долоон бурхан од (*Ursa Majoris*)-ыг нэн эртнээс монголчууд шүтэж, тахиж иржээ. “Монголын аль ч нутагт үдэш орой сүү саалийнхаа дээжийг долоон бурханд өргөж, мал идээгээ даатгадаггүй айл гэж байсангүй. Тэр ч байтугай, аян жингээр нутаг уснаасаа хол яваа хүмүүс аяныхаа хоол хүнснээс оддын тоогоор хувилж, долоон бурханд зориулан өргөдөг байжээ. Ялангуяа мал сүрэг хээр хонох тохиолдолд түүнд бүр тусгайлан өргөл тахилаа зориулан, хээрийн чоно араатнаас

аварч хамгаалж өгөхийг даатгаж гуйдаг уламжлал өргөн дэлгэр байв." /БНМАУ-ын угсаатны зүй, 1989, 386-387/

Үүнээс үзвэл долоон бурхан одыг нүүдэлчин монголчууд мал ахуй, өмч хөрөнгө, заяа тавилан, насан хутгийг харж сахиж байдаг хэмээн үзэж шүтэж байдгийг гэрчилж байна. Ийнхүү үзэж төсөөлөх болсон гол үндэслэл нь жилийн аль ч улиралд үргэлжид шөнийн тэнгэрт алтан гадсыг тойрон эргэлдэж үзэгддэг явдал байсан хийгээд тиймээс л тэднийг өвгөд дээдсийн дүрд дэвшүүлж, үнэтэй (хэрэгтэй) бүхнээ түүнд даатган сахиулж, онцгойлон тайж тахьдаг болсон ажээ. Тиймээс ч энэ тухай Вальтер Хайссиг "Монголчууд дохиур долоон одыг заяаны сахиулсан болгон "долоон өвгөн" гэж тахидаг. Бас заримдаан үржүүлэгч сахиулсан болон өсгөгч сахиулсаны чадварыг дохиур долоон од ба бусад од мичдэд тохдог" /Хайссиг, 1998, 143/ хэмээн өгүүлжээ.

Долоон өвгөн одыг онцгойлон тахин шүтэж байсны бас нэгэн тод нотолгоо "Долоон өвгөн хэмээх одны судар" болно. "Хүй ихэт ерөн есөн тэнгэр, хөвчин ихэт далан долоон этүгэн эхээс үүдсэн ерөн түмэн одны дундаас долоон өвгөн нэрт одонд есөн зул, есөн хүж, жимс, цай, архи, халзан цагаан хонь, есөн цацал бэлдэж ариун тахил тахин мөргүнэм. Алтан од, гэрэлт алиман саран туяат арван түмэн одны дундаас долоон өвгөн нэрт одонд ариун тахил тахинам. Мөнгөн одон гэрэлт, мөгүриг саран туяат монгүй олон одон гэрэлт, дүгэриг саран туяат түг түмэн одны дундаас Долоон өвгөн нэрт одонд ариун тахил тахинам. Хутаг хишиг нь өдөр энд оршитугай. Ийм жилт, тийм омогт өчүүхэн хүнийг харахыг жиргай болтугай. Харвах эрхийг оном заяатугай гэж ариун тахил тахинам. Нарийн ганзагыг цусан дээр, навтгар хормойг тосон дээр заяатугай гэж ариун тахил тахинам. Улаан үнэгийг буруу бөгрөг гэж унах морийг зөвөөр хөдлөтүгэй гэж ариун тахил тахинам. Хөх чоныг буруу бөгрөг гэж, хөтлөх морийг зөвөөр заяатугай гэж ариун ариун тахил тахинам..." (Дамдинсүрэн, 2001, 7) гэх мэтээр цааш өгүүлэх эл судар хэд хэдэн хувилбартай ажээ.

Түүнчлэн Ц.Дамдинсүрэн энэ Долоон одны судрыг урьд ардын аман зохиолын гаралтай бөө мөргөлийн зохиол байгаад хожим "Бурхан номлосон", "Долоон түүнчлэн ирсэнд мөргөмүй", "Бурхан Манзушир бодьсатвад зарлиг болруун" гэх мэт үгийг улам улмаар нэмсээр байгаад бурханы судрын шинжийг олж Ганжуурын дотор багтаж орсон мэт байна гэж үзжээ. Мөн энэхүү сударт тогтоосон долоон өвгөн нэрт одонд зул барих өдөр нь жил бүрийн хувь сарын

долоон шинэд, хоёр сарын дөрвөн шинэд, гурван сарын хоёр шинэд, дөрвөн сарын хорин долоонд, таван сарын таван шинэд, зургаан сарын хорин гурванд, долоон сарын хоринд, найман сарын арван долоонд, есөн сарын хоринд, арван сарын арван нэгэнд, арван нэгэн сарын арван таванд, арван хоёр сарын найманы шинэд ажээ. (Дамдинсүрэн, 2001, 3)

Мөн миний бие 2003 оны 6-р сарын 14 буюу ХҮИ жарны Харагчин могой жилийн зуны тэргүүн могой сарын 15-ны могой өдрийн Отгонтэнгэр уулын тэнгэрийг тайх төрийн их тахилгыг үзэж сонирхсон бөгөөд тахилгын өмнөх шөнө (14-15) олон хуврагууд Долоон бурхан одыг газарт чулуу овоолон үйлдэж, ном хурахуйд сүсэгтэн олон өөр өөрсдийн жилийг даагч одыг заалган залбирал үйлдэж байсан юм.

Долоон бурхан одны *долоо* нь тухайн оддын тоо, *бурхан* гэдэг нь эртний хүмүүс оддыг хүншүүлэн төсөөлдөг үзэл ойлголтын нэгэн жишээ болохыг харуулах хийгээд чингэхдээ хүмүүний түвшнээс дээш дэвшүүлэн бурханчилсан дүр, басхүү дээр өгүүлсэн түүний ариун их сахиулсан үүргийг илэрхийлж байна. Гэхдээ “*бурхан*” гэсэн нэр нь буддын шашин дэлгэрсний дараах хэрэг бөгөөд үүнээс өмнө түүнийг “*Долоон өвгөн*” гэдэг байжээ. Энэ нь өвгөдийг шүтэх эртний нүүдэлчдийн уламжлалт шүтлэг дэх унаган субъектүүд буюу дээрх утга бэлгэдлийн жинхэнэ эзэд гэсэн үг юм.

Долоон өвгөн одыг монголчууд Тэнгэрийн оргилого, Тэнгэрийн хас, Тэнгэрийн шил, Тэнгэрийн эрх, Тэнгэрийн бэрээ, Нэхэх арга, Жиргэлэх гэрэл /Намнандорж, 1989/, /Нинжбадгар, 2003, 118/ хэмээн нэрлэдэг хийгээд харин Нэхэх арга одны дэргэдэх хүмүүний харааг шалгагч бяцхан одыг Туслагч /Алькор/ гэдэг.

Эдгээр одыг монголчуудын домог зүйд үзэхдээ: Өөр өөрийн өвөрмөц эрдэм чадал бүхүй долоон баатар эрс байгаад бие биесээ танин олж, ах дүү анд бололцож дайснаа дарж, дархан цолоо олоод, улмаар тэнгэрт дэвшин гарч Долоон өвгөн од болцгоосон хэмээн үздэг. (Дулам, 1989, 96) Домгийн эл өгүүлэмж нь өнөөг хүртэл халх, ордос, дархад, буриад, баруун монголчуудын дунд өвөрмөц хувилбартайгаар яригдаж иржээ. Уг домгийн баатрууд нь уул өргөдөг, шувууны хэл мэддэг, гурван тивийнхний юу ярилцаж буйг сонсдог, тэнгэрийн од мичдийг харвах чадалтай зэрэг тус бүрдээ ид шидийн авъяас төгс эрдэм чадалтай байдаг нь монгол домгийн соёлт баатрууд гэдгийг харуулна. Домгийн халх хувилбарт ах дүү

долуул тэнгэрт дэвшин гарах цагт Мичид зургаан¹ од тэсгэм их хүйтнийг гаргах тул нэг одыг нь авснаас хойш аяруу дулаан болсон юм гэдэг. Тэр нь одоо Долоон өвгөн одны сүүл хавьцаах бүдэгхэн жижиг од² (Беннигсон, 1912, 57) мөн (Дулам, 1989, 104) гэдэг. Зарим нутагт тэрхүү бүдэг одыг ах дүү долоогийн дундаа авсан эхнэр нь гэж өгүүлдэг. Үүнээс үүдэн уул домгийг Мичид болон бусад одны домогтой нэгэн орчилд багтаж байсан хэмээн доктор С.Дулам үзжээ. (мөн тэнд) Юу боловч эл домогт тэдгээр долоон од нэгэн цагт энэ дэлхий дээр хүн байгаад тэнгэрт дэвшин гарснаар ах дүү одод буюу долоон өвгөн болцгоосон тухай тодорхой өгүүлжээ. Энэ нь монголчууд од эрхсийг хүн хэмээн үзэж төсөөлдгийн тод жишээ ажээ.

Долоон өвгөн одны хоёр дахь хувилбар нь үүнээс өвөрмөц хийгээд дөрвөдүүдийн дунд элбэг тохиолдох учир С.Дулам домгийн ойрд хувилбар хэмээн үзжээ. Энд дээрх домгийн өгүүлэмжээс өөр буюу Аман Цагаан гэдэг нэгэн баатрын бие цацарч, долоон од болон хувилсан (Потанин, 1883, 194) гэж тайлдаг. Домгийн гол баатар Аман Цагаан нь грек домгийн минотавр Астерионорхуу үхэр төрхтэй, доод бие бух шиг сүүлтэй, домгийн уран сэтгэмжийн дүр байдаг. Гэхдээ энэ нь грек домгийн минотавр шиг хорлолт бус, харин морин хүн кенотавр шиг сайхан сэтгэлт, агуу чадалт, эр зоригт баатар байдаг. (Дулам, 1989, 104) Магадгүй энэ хувилбарын гол өгүүлэмж нь монгол нутаг дахь эртний нүүдэлчдийн сэтгэмжээс төрөөгүй харин өөр ард түмнээс буюу өрнө дахинд буй болсон домгоос эхтэй байж болох юм. Тэглээ ч бас энэ нь тухайн оддыг хүншүүлэн үзснийг илэрхийлж байна.

Зүүн өмнөд Азийн ард түмэнд Долоон бурхан, Тэнгэрийн гох³ одны ордтой холбогдсон нэгэн домог байдаг. “Эрт урьдын цагт нэгэн Хуандихүүг түүний улаач нь их тэргэндээ суулган газар дэлхийн хамгийн төв хэсэгт байх үхэлгүй мөнхийн Куэнь-Лунь ууланд хүргэжээ. Тэрхүү ууланд мөнх орших бурхад, уул усны эзэд ид шид гайхамшиг бүрдсэн цэцэрлэгтэй. Үлгэрийн модод ургасан уг цэцэрлэг улирлын аль ч цагт төрөл бүрийн жимсээр элбэг байх агаад тэдгээрээс хамгийн

¹ Мичид маш олон оддын бөөгнөрөл хийгээд энгийн нүдээр долоон од харагддагийн зургаа нь үзэгдэх гэрэл ижлэвтэр, харин нэг нь бүдэг болно. Үүнийг тэр бүр олж хардаггүйгээс өвлийн саруудын шинэдээр, эсхүл хуучдаарх шөнийн тэнгэрт харагдах боломж ихэсдэг. Тийнхүү зургаа бус долоо болж үзэгдэхийг монголчууд бид Мичид зулзаглах хэмээдэг ба тэрхүү долоодох бүдгийг энд өгүүлж буй ажээ. Ю.Б.

² Нэхэх арга одны дэргэдэх хүний хараа шалгагч гэгддэг Туслагч од Алькор Ю.Б.

³ Тэнгэрийн гох /Serpheus/ - зарим хэсэг нь тэнгэрийн заадлын дагуу байрласан. Ертөнцийн умард туйл орчмын одны орд

гайхалтай нь нэгэн тоорын мод ажгуу. Түүний жимсийг идсэн хэн бүхэн бурхны шидийг олж, насан хутаг нь нэмэгддэг. Шидэт цэцэрлэгийн эзэн бээр гурван мянган жилд нэг удаа бурхад болон зарим тэнгэрт хальсан хүмүүсийг урьж үхэлгүй мөнхийн шидийг агуулсан жимсээ амтлуулдаг байжээ. Нэгэн удаагийн тэр л өдөр улаач найман агсам морьдоо их тэргэндээ хөллөж Хуандихүүг суулган ниссээр гайхамшигт цэцэрлэгт хүрч, үхэлгүй мөнхийн шидэт жимсийг идэж, эргэж буцах нь битгий хэл ер цаг хугацааг умартан саатжээ. Тэр цагаас хойш тэднийг хэн ч энэ газар дэлхий дээр үзээгүй бөгөөд харин улаач тэнд үлдсэнгүйгээр тэнгэрт гарахуйд бурхад түүнийг Тэнгэрийн гох /Cepheus/, тэргийг нь Долоон бурхан од /Ursa Majoris/ болгон хувиргасан ажээ. Харин тэр цагаас одоог хүртэл хүмүүс шөнийн тэнгэрт мөнхийн хутгийг олсон улаачийг тэрэгтэй нь хамт үзэх болжээ. (Ангел Бонов, 1984, 50-51)

Үүнээс үзвэл хятад болоод зүүн өмнөд Азийн ард түмнүүд Тэнгэрийн гох оддыг Хуандихүүгийн улаачаар, харин Долоон өвгөн оддыг түүний тэргээр төсөөлдөг ажээ. Харин Долоон өвгөн оддын тухай өрнө дахины домгийг авч үзвэл:

Эрт урьдын цагт Аркадийн улсыг Ликаон хаан хаанчилж байжээ. Тэрвээр ертөнцөд гоо үзэсгэлэнгээрээ гайхагдсан Каллисто гэгч охинтой юм санжээ. Гэтэл тэнгэр газрын аянга цахилгааныг эзэгнэгч Зэвс түүний үзэсгэлэн гоог үзэж биширчээ. Тэрээр өөрийн хартай хатан Герагаас нуугдан байж Каллистогийн эцгийнд байнга очих болж улмаар Аркадий хэмээх хүүтэй болжээ. Хүү царайлгийн дээр тэгш сайхан бие галбиртай болж ер бусын түргэн өсч торнисон агаад басхүү харваж намнахдаа хавтай сайн болжээ. Гэтэл нэгэн удаа Зэвс Каллисто хоёрын хайр дурлалын явдлыг хартай хатан Гера мэдэж уур хилэндээ шатаж, үзэсгэлэн төгс Каллистог эм баавгай эвш болгон хувиргажээ. Нэгэн үдэш Аркадий хүү ан хийж ирэхүйд гэртээ эвш байхыг үзжээ. Төрсөн эхээ эвш болсныг мэдэхгүй тэрвээр нумаа хөвчлөн харавтал Зэвс эвшийн сүүлнээс шүүрч тэнгэрт гаргажээ. Тийнхүү сүүлнээс нь татаж гаргасан учир тэнгэр дэх баавгайн сүүл их урт болсон гэдэг. Үүний дараа Каллисто өөрийн хамгийн дотно зарц нэгнийг бас тэнгэрт гарган Бага долоон бурхан болгосон бол харин Зэвс хүү Аркадийг Шилээврийн орд⁴ болгожээ. Чингэхдээ түүнийг өөрийн эх Долоон бурханыг үргэлж мөнхөд хамгаалж байхаар тэнгэрт дэвшүүлжээ. Иймээс Шилээврийн орд нь Долоон бурханы араас юу юугүй

⁴ Шилээврийн орд /Bootes/ - Волопас

хөөж гүйцэхийг завдах өөрийн анч нохдын уяа оосрыг чанга сойн барьж байгаа мэт харагддаг ажээ.

Энэ тухай өөр нэгэн хувилбарт: Мөнхийн залуу охин тэнгэр Артемида зэр зэвсгээн агсан тураг ан авлахаар ой тайгаар байнга хэрэн хэсдэг байжээ. Түүний араас бараа бологч, албат дагуулууд нь уулсын хяр дамжин дуу дуулж, инээлдэж хөхрөлдөн явдаг байж. Тэдгээр охид бие биесээсээ ялгарахаар өөр өөрийн өвөрмөц сайхан өнгө зүстэйгээс үзэсгэлэн гоогоороо гайхагдсан нь Каллисто байжээ. Гэтэл нэгэн удаа Зэвс түүнийг харж үзэсгэлэн гоог нь биширчээ. Гэвч Артемидийн албатууд гэрлэх хориотой байж. Тиймээс Зэвс арга сэтгэн нэгэн шөнө Артемийн дүрд хувиран Каллистогийн өмнө гарч иржээ. Чингэсээр Каллисто хүү Артемидийг төрүүлсэн нь хэнийг ч дагуулахгүй сайн анчин болжээ. Гэтэл Зэвсийн хатан Гера нөхрийнхөө хайр дурлалын холбоог мэдэж Каллистод ихэд уурсан хилэгнэхдээ түүнийг болхи бүдүүн эвшид хувиргачихжээ. Түүний дараа хүү Аркадий ой хөвчид явж байгаад гэнэт тэр эвштэй тааралджээ. Тэрээр өөрийн эхийг гэж мэдэлгүй харвахад хайртай Каллистогоо цаг ямагт харж хамгаалж байсан Зэвс сүүлийн мөчид амжин сумны чигийг өөрчилж эвшийн дэргэдүүр өнгөрүүлжээ. Чингэх зуур Зэвс Аркадий хүүгээ бяцхан бамбарууш болгож, эхийнх нь хамт сүүлнээс шүүрч дүүгүүрдэн тэнгэрт гаргасанд үзэсгэлэнтэй сайхан Их⁵, Бага баавгай⁶ одод болсон ажээ. Чингэхдээ тэнгэрийн хойд хаяанд газар дэлхий дээр байснаасаа ч илүү сайхан харагдах болжээ. (Ангел Бонов, 1984, 22-24)

Домгийн энэхүү хоёр хувилбараас үзвэл өрнө дахин Долоон өвгөн одыг Зэвсийн үзэсгэлэнт амраг Каллистогийн хувирсан дүр гэх баавгайгаар үзэж төсөөлдөг байна. (Щеглов П.В. 1986, 75) Тэгээд ч Арктик буюу хойд туйлын нэр нь *Arctos=Arctus* баавгай гэсэн грег үгнээс үүссэн хийгээд Арктика гэдэг нь Баавгайн орон гэсэн утгатай байгаад хожим нь ерөөс умард туйлын нэр болж үлдсэн ажээ. (Ангел Бонов, 1984) Энэ нь эртний грегүүд ертөнцийн умард зүгт баавгайн орон байдаг хэмээн үзэж төсөөлж байсныг илтгэн харуулах төдийгүй манай тооллын эхэн үеийн сурвалж бичгүүдэд ч умард Европын ард түмнүүдийг Баавгайн орны хүмүүс хэмээн нэрлэж байсан ажээ. Ер нь хүн төрөлхтний соёл иргэншлийн эх өлгий болсон Евроазийн эх газар нь өргөрөгийн хувьд хойшлох тусам хүйтэн

⁵ Их баавгай од /*Ursus majoris*/ - Долоон өвгөн од буюу Их долоон бурхан

⁶ Бага баавгай /*Ursus minoris*/ - Алтан мөнгөн шаргуудын орд буюу өдгөө бидний ярьж заншсанчлан Бага долоон бурхан

сэрүүн болж шивэр (Сибирь) их ой хөвчөөр бүрхэгдэх хийгээд энэ нь хүрэн баавгайн⁷ амьдарч нутаглах таатай орчин нь болсоор ирсэн төдийгүй туйлын бүсэд хуурай газрын хамгийн том араатан болох цагаан баавгай хүртэл амьдардаг нь эртний энэ үзлийн төлөвшилд ихээр нөлөөлсөн нь эргэлзээгүй. Тэгээд ч барууны ертөнц орос орныг баавгайгаар бэлгэдэх нь өдгөө ч хадгалагдахын зэрэгцээ 1980 оны Москвагийн XXII олимпийн бэлгэ тэмдэг "Мыша" нэртэй бамбарууш байсан явдал ч тохиолдлын хэрэг биш билээ.

Энэ бүхнээс өрнө дахинд Долоон өвгөн од болон Алтан, мөнгөн шаргуудын ордны одод нь баавгайгаар, харин хятад болон зүүн өмнөд Азийн зарим ард түмнүүдийн домогт Хуандихүүгийн улаачийн хөсөг тэргээр төсөөлөгддөг бол Монголчууд эдгээрээс ихэд өвөрмөц байдлаар буюу тэдгээр од тус бүрийг тэнгэрт дэвшин одсон өвөг баатруудын (Болдбаатар 2006, 160) дүрээр үзэж сэтгэдэг ажээ.

Алтан гадас од

Нарнаас 120 дахин их голчтой, 600 дахин их гэрэл цацруулдаг, 780 гэрлийн жилийн зайд орших жижиг дагуул од бүхүй α хэт аварга од Алтан гадас нь монголчуудын хувьд Алтан, мөнгөн шаргуудын ордонд багтдаг. Уг од хойд туйлаас 1°-ийн зайд байрлах авч энгийн нүдэнд нэгэн цэгт хөдөлгөөнгүй оршиж харагддагаас хойд зүг-чигийг заагч од болдог. Хөдөлгөөнгүй орших энэ л онцлог шинжид үндэслэгдэж өргөн уудам дайдад мал адгуулан нүүдэллэн амьдрах монголчуудын огторгуйн сэтгэлгээнд одтой тэнгэрийн голд шаагдсан хөдөлгөөнгүй гадас хэмээн амьдрал ахуй дахь хэрэглээний эд зүйлтэй адилтгасан буюу чингэхдээ тэнгэрийн хүү Хөхдэй мэргэний алтан (β од), мөнгөн шарга (γ од) морьдыг аргамжсан аргамжаа(η , ι , ϵ , δ одод нь)-ны гадсаар үзэж төсөөлөгдсөн ажээ. Огторгуйн²² ертөнц дэх энэ зураг нь мал адгуулах нүүдэлчдийн л

⁷ Хүрэн баавгай – латин нэр нь - *Ursus arctos* - үгчилвэл - *туйлын баавгай* гэсэн утгатай ч үгийн гарвал нь үнэндээ эртний латины *Ursus*, грекийн *Arctos* буюу хоёул баавгай гэсэн үг болно.

²² Огторгуй – Судлаачид энэ үгийг *огм-ор-үгүй* гэж задлан сансрын орон зайн хязгааргүй уудам шинжийг илэрхийлсэн утгатай хэмээн тайлбарладаг. Тэгвэл *огторгуйн оёдол* гэж тэнгэрийн заадлыг нэрлэх нь буй. Эндээс бидний өвөг сэтгэлгээний өвөрмөц дүр зургийг харах бололцоо харагдаж байна. Учир нь гэр барихад хойд урдах дээврийг зөрүүлдэг шиг л огторгуйг нийлүүлж оёж бүтээсэн тухай (архетипийн сонгодог нэгэн жишээ) үзэл төсөөлөл уг үгсийн утгаас илэрхий хийгээд энэ нь тэнгэрийн гадаад хил хязгаар, хэлбэр, хэв шинжийг илэрхийлж байна. Түүнчлэн монголчууд тарвагыг хулгар шар гэхээс гадна *оготор шар* гэж нэрлэдэг. Эдгээр нь түүний чихний онцлогоос үүдсэн болох нь илэрхий хийгээд нүхэнд амьдрагч жижиг мэрэгчдийг бид *оготно*, *хулгана* хэмээн ангилж нэрлэдгийн –*qul-* буюу *хул* гэдэг нь эртний түрэг, монголчуудын чих гэсэн үг бөгөөд хулан гэдэг нь том чихтэй битүү туурайтныг, хулгана гэдэг нь том чихтэй мэрэгч амьтныг харин оготно

сэтгэлгээний туурвил болох нь илт байна. Алтан хэмээн тодотгосон явдал нь өөрийн нь өнгийг илтгэсэн бус цэвэр бэлгэдлийн шинжийг илэрхийлсэн буюу төмөрлөгийн дээд эдээр өргөмжилсөн хэрэг болно. Мөн ийнхүү бэлгэдэж тодотгосон явдалд зөвхөн Алтан, мөнгөн шаргуудыг аргамжсанаас гадна Долоон өвгөн хийгээд тэнгэрийн бусад бүхий л оддыг аргамжсан төв од, түүнчлэн зүгчигийг гол тодорхойлогч зэрэг гол онцлог шинжүүд нөлөөлсөн нь эргэлзээгүй. Харин түрэг хэлт ард түмнүүд уг одыг төмөр гадас (Темир казык) гэдэг. Энэ нь тухайн одны нүдэнд үзэгдэх өнгийг илэрхийлсэн хэрэг ажээ.

Дээр өгүүлсэн Долоон өвгөн хэмээх одны судрын нэгэн хувилбарт “Этүгэн эхээс дээр найман түмэн дөрвөн мянган бээр өндөр биет сүмбэр уулын оргил дээр суурьт буюу чи тэнгэр минь” (Дамдинсүрэн, 2001, 3) хэмээн долоон өвгөн одыг өгүүлсэн нь Монголчуудын сэтгэлгээн дэх ертөнцийн уул буюу Сүмбэр уулын оройд суурьлагдсан болох нь харагдана. Ингэхдээ Сүмбэр уулын оройд Алтан гадас од байрлах ба энэ нь ертөнц хийгээд тэнгэр хурмастын төв болж түүнд Долоон өвгөн од бэхлэгдэн ертөнцийн хөдөлгөөнийг илэрхийлж байдаг ажээ. Энэ талаар Мирча Элиаде Энэтхэгийн шүтлэгт Меру уул ертөнцийн төвд сүндэрлэх бөгөөд түүний дээр Алтан гадас /од/ гялалзана. Харин Урал Алтай (хэлт-Ю.Б.) ард түмнүүд (жишээлбэл буриадууд) мөн Сүмэру (Сүмбэр уулын самгарьд нэр Ю.Б) гэдэг оргилд нь Алтан гадсыг бэхэлсэн Төв уулыг мэддэг байна. Энэ нь Энэтхэгийн нөлөөг илтгэж байгаагийн дээр Монголчууд, Халимагууд түүнийг 3 буюу 4 үелсэн гэж төсөөлдөг байхад сибирийн татарууд түүнийг 9 үетэй гэнэ. Якутын бөө мөн 7 үетэй уулаар тэнгэрт гарна. Түүний оргил нь Алтан гадас одны хажууд, /Тэнгэрийн хүйс/ байдаг газар байна. (Мирча Элиаде 1987;39,147)

Алтан гадас од бол Ордост хийгддэг Чингисийн тайлгат онцгой утга агуулгатай байдаг. Чингисийн цомцог ордоны өмнө алтан гадас одыг бэлгэдсэн нэгэн хүний хөлийг нь газар булан зогсоож “Алтан гадас” гэж нэрлэдэг. Алтан

гэдэг нь оготор чихтэй мэрэгчдийг ялган нэрлэж байгаа ажээ. Эдгээр *оготор* чихтэй амьтадын чихний онцлог шинж нь юу вэ гэвэл чих нь жижигхэнээс гадна хамгийн гол нь гадаад ирмэг хөвөө нь дугуйлж *огтолсон* мэт ажгуу. Тиймээс *ОГТОРГУЙ* гэдэг нь тэнгэрийн орны зах хязгаарын хэлбэр, хэв шинжийг заасан утгатай буюу дотор талаас нь илэрхийлвэл хүнхэр, гадна талаас нь бол бөмбөгөр (гэр бол сансарын бичил загвар гэж нүүдэлчид сэтгэдэг. Тэнгэр огторгуйг ийнхүү сэтгэх нь бидний нүдэнд харагдахуй гадаад ертөнцийн ерөнхий төрх байдлаас үүдсэн хэрэг хийгээд тэнгэрийн хаяа гэдэг үг ч гэртэй ижилсүүлж төсөөлж буйн тод жишээ юм) хэлбэртэй болохыг илэрхийлж байна. Энэ нь хүн төрөлхтний орчлонгийн хэлбэрийг төсөөлж асан нийтлэг үзэл төсөөлөлтэй нийцнэ. Чингэснээр огторгуйгаас чинагш басхүү орон зай буй гэсэн ухагдахуун бас илэрнэ.


урагтны дээдсийн тахилгын судрыг уншиж байх цагт тэр хүмүүн ер хөдөлдөггүй. Алтан гадас одны иймэрхүү хүмүүнчлэл нь амьд хүмүүний тахилгыг бэлгэдэж байгаа нь уу? (Хайссиг 1998; 143) Буриадууд бол алтан гадас одыг амьд хүмүүнээр тахидаг.” (Дорж Банзаров, 1846, 73) гэсэн бол Шаралдай гуай энэ тухай “Алтан гадас бол цагаан сүргийн их тайлгад заавал оролцдог түүх соёлын дурсгал юм. Алтан гадас гэдэг нь Чингис хааны онгон шүтээний хаврын сүүл сарын 21-ний цагаан сүргийн их тайлга дээр Чингис хааны өндгөн цагаан шүтээн гэгч моринд⁸ багана гадас болон зогсдог Гадас овогтон хүнийг хэлж буй. Энэ тухай Жамсраны Цэвээн 1910 онд Чингис хааны цагаан сүргийн их тайлгад биеэр оролцоход “Алтан гадас бол Чингисийн морины уяаны алтан гадсыг орлон хөдөлгөөнгүй зогсдог хүн юм. Энэ хүний өвөг дээдэс жинхэнэ алтан гадсыг алдаж осолдсон учраас тайлгын өдөр тийнхүү гадас болон зогсч байх болсон” гэжээ. (Шаралдай, 1999, 195)

Хас тэмдгийн махбодь бол Алтан гадас од төвтэйгээр, түүнийг тойрох долоон өвгөн одны хосгүй гайхамшигтай байрлал, түүний хөдөлгөөний дөрвөн цагийн эргэлтэнд, дөрвөн зүгтэй хэрхэн зохирч байгаад үндэслэгдэж зохиогдсон одтой тэнгэр, орчлонгийн орон зай, цаг хугацааны, өөрөөр хэлбэл зогсолтгүй эргэх, (цагийн зүүний эргэлт адил) мөнхийн хэмнэлт хөдөлгөөнийг илэрхийлсэн орчлонгийн хүрд, ертөнцийн тэгш хэмийн бэлгэ тэмдэг мөн. Энэ нь байгалийн хүрээлэл дундах эртний хүмүүсийн од эрхсийн орчил, хөдөлгөөнийг ажигласан ажиглалтаас эх загвараа авсан тэмдэгт ажээ.

Долоон өвгөн одыг нүүдэлчин монголчууд өрнө, дорнын ард түмнүүдээс өөрөөр буюу долоон өвгөдийн дүрээр үзэж сэтгэж ирсэн ба тэд өвгөд өдөр шөнө хийгээд дөрвөн цагийн эргэлтэнд хүмүүний мал ахуй, өмч хөрөнгө, заяа тавилан, насан хутгийг харж сахиж байдаг ажээ. Тиймээс оддын дотроос онцгойлон шүтэж, тайж тахисаар иржээ. Энэ нь өвгөдийг шүтэх шүтлэгтэй шууд холбогдох ажгуу.

Монголчуудын үзлээр Алтан гадас од нь орчлон ертөнцийн төв буюу одтой тэнгэрийн эргэх хөдөлгөөний гол тэнхлэг болсон од ажээ.

⁸ Өгүүлэгч миний бие 2000 оны 8 сард Өвөр Монголын Өөртөөн засах орны Их зуу аймгийн нутаг дахь Эзэн хороонд очихуйд Их эзний өндгөн цагаан хүлэг нь шарга зүстэй байсан нь Хөхдэй мэргэний алтан шарга морь буюу Алтан мөнгөн шаргын ордны β Алтан шарга одны бэлгэдэл хүлэг байж болох мэт. Ийнхүү үзвэл Чингис хаан тэнгэрийн хүү Хөхдэй мэргэний дүрд ижилсэж болох юм.



Долоон өвгөн одны нэрс: 1. Тэнгэрийн оргилог 2. Тэнгэрийн хас 3. Тэнгэрийн шил
4. Тэнгэрийн эрх 5. Тэнгэрийн бариа 6. Нэхэх арга /Хажуугийн жижиг од
Туслагч/ 7. Жиргэлэх гэрэл

Ном зүй

Болдбаатар Ю. 2006, Хөхдэй мэргэн од түүний домгийн учир холбогдол,
/Mongolian

Journal of Anthropology, Archaeology and Ethnology/, Vol.2, No.1(254), УБ.,
х.152-163

Бонов Ангел, 1978. Митове и легенди за съзвездията, /Издателство наука и
изкуство/, София., 1984. Мифы и легенды о созвездиях. Минск

БНМАУ-ын угсаатны зүй, 1987, Улаанбаатар
Дулам С., 1989, Монгол домог зүйн дүр, УБ.

- Дамдинсүрэн Ц. 2001, "Долоон өвгөн хэмээх одны судар оршив" /Монголын уран зохиолын дээж зуун билиг оршив/, II, УБ.
- Дорж Банзаров, 1846, "Харын шашин", Казань,
- Мирча Элиаде, 1987 "Космос и история", Москва, Прогресс
- Намнандорж О., 1989. Одны орд, од, гаригийн нэрс. УБ.
- Нинжбадгар С. Даваабаяр С. 2003 "ХҮII жарны "Наран" хэмээх усан хонин жилийн монгол зурхайн цаг улирлын тооны бичиг (2003-2004)", УБ.
- Потанин Г.Н. 1881-1883, "Очерки северозападной Монголии", Вып.2, 4, -СПб.
- Хайссиг Вальтер 1998, "Монголын шашин суртахуун", Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо
- Шаралдай Хэрээд, 1999, "Чингис хааны онгон шүтээний тайлга тахилга", УБ.
- Щеглов П.В. 1986, "Отраженные в небе мифы Земли", Москва